



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/122

Мандалговь

“Ашид бьюлдинг” ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/66 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Эрүүл мэндийн төвийн их засвар (Дундговь, Адаацаг сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай 85,040,104 (наян таван сая дөчин мянга нэг зуун дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг) нарт ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060500